



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-9</i>
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	<i>4-8</i>
<i>2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>8-9</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 18-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 09 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

**Чөлөөтэй: Ж.Батсуурь, С.Одонтуяа, Ч.Хүрэлбаатар;
Тасалсан: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн.**

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 09 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 09 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМААА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан” танхим 09 цаг 09 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Та бүхэнд Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулъя.

Ганзоригийн Тэмүүлэн миний бие, Ганибалын Амартүвшин, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн, Баттогтохын Чойжилсүрэн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны нийт гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээр асуудал. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх.

2 дугаар асуудал. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан сайд, Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат, дарга нараа дуудаарай. Эхнээс нь танилцуулж байя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Барсүрэнгийн Баасандорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Үүрцайхын Амарбат, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Дагва-Очирын Бумдарь, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Чойжилсүрэнгийн Ариунхур. Тэргүүн дэд дарга, сайдыг дуудаарай.

Хэлэлцүүлэг эхлэхийн өмнө та бүхэнд холбогдох хуулийн заалтуудыг уншиж танилцуулъя.

Амарбаясгалан дарга орж ирлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргана гэж заасан байгаа.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү.

Раднаасэд гишүүнээр тасалъя. Раднаасэд гишүүн асуулт асууна. Байнгын хороогоор уг асуудлыг хэлэлцэхэд бас гишүүний асуулт асуух хугацаа нь 8 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, гишүүний асуултад хариулах хугацаа 8 минутаас илүүгүй, тайлбар өгөх хугацаа нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байна гээд заасан юм байна.

Ингээд Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: 21.2 дугаар зүйл, Үндсэн хуулийн 2 дахь хэсэг шууд сонгоно гэж байгаа ард иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд гээд. 12 оны Сонгуулийн хууль батлагдсаны дараа Үндсэн хуулийн цэц дээр биш пропорциональ системийг унагаах бас нэг заалт чинь өөрөө шууд гэдэг үг явсан. Тэр чинь хүн сонгоно гэсэн үг ээ гэж, тайлбарлагдаж. Тэр заалт чинь одоо яг үүгээрээ явах уу? Одоо энэ сая бол хөндөөгүй шүү дээ, Засгийн газраас орж ирэхэд.

Тэгэхээр пропорциональ гэдэг чинь одоо бол зүгээр ерөнхий яваад байгаа шүү дээ. Дотроо энэ чинь 3, 4 төрөлтэй ч юм байгаа байх. Нээлттэй, хаалттай гээд тийм ээ. Нам дугуйлах уу, хүн дугуйлах уу, эс үгүй бол намын жагсаалтын ард бичигдсэн. Тэгээд энэ дээр бол ерөнхий 1 томоор биччихэж байгаа байхгүй юу. Үүнийг яг юу гэж ойлгож оруулж ирсэн

юм? Шууд гэдэг үгийг хөндөөгүйн шалтгаан. Үгүй ээ, энэ бол шинжлэх ухааны тайлбар байхгүй юу. Яг хуульчид яг энэ Үндсэн хууль судалдаг хүмүүсийн шинжлэх ухааны яасан тайлбар байх ёстой байхгүй юу.

2 дахь юм, одоо ингээд 76, 50 гээд хуваагдчихлаа. Энэ зүгээр томъёолоо их зөв гаргахгүй бол өмнө нь 21.1 чинь болохоор 1 танхимтай 76 гишүүнтэй байна гээд ингээд явсан. Ямар ч тогтолцооны өгүүлбэр байгаагүй. Одоо ингээд 76 нь мажоритар, 50 пропорциональ ч гэдэг юм уу ингээд явахаар ерөнхийд нь ингээд биччих юм бол агуулгаар нь биччих юм бол наад чинь үүнийг хэрэглэхэд энэ сонгуулийг 2 хувааж явуулж болох юм байна. Энэ жилдээ мажоритарыг нь явуулъя, дараа жил нь пропорционалийг нь явуулъя ч гэдэг юм уу хожмын өдрүүдэд дахиад энэ Үндсэн хуулийг чинь мушгих ийм нүх нээх вий дээ. Яг одоо бол орж ирснээс чинь ингээд харахад, ирчихсэн байгаагаас харахад 50, 50-аар 76, 76-гаар 2 үе шаттай, 2 үе шаттай ч юу байх вэ дээ, 2 салгаж сонгууль явуулах ийм нөхцөл байх вий гэж. Би тэгээд болгоомжлох үүднээс 2 дахь асуулт гэх юм уу үүнийгээ бас яаж тооцож бодож орж ирсэн юм бол гэж.

Эхнийх нь бол одоо энэ пропорциональ гэдэг үг чинь ерөөсөө хөдлөхгүй байгаад байна шүү дээ. Яг нээлттэй нь явах юм уу, хаалттай нь явах юм уу.

Хэрвээ нээлттэй гэж байгаа бол энэ чинь зөв. Энэ дотроо харин нээлттэй, хувь тэнцүүлэх хуваарилах зарчмаар одоо хувь тэнцүүлэн хуваарилах зарчмаар явуулна гэж хэлэхэд.

Хаалттай гэх юм бол энэ шууд гэдэг үгтэй чинь очиж мөргөлдөх үү? Тэгээд бид нар өнөөдөр энд ойлгох биш яг энэ дээр хожмын өдөр 5 жилийн дараа, 10 жилийн дараа үүнийг хэн нэгэн уншихад ямар нэгэн байдлаар өөртөө ашигтай байдлаар тайлбарлах боломж өгөхгүй

байдалд бичигдэх ёстой л гэж ойлгоод байгаа байхгүй юу. Ямар ч хүн уншихад ижил түвшинд ойлгодог ийм ойлголт төрүүлэхгүйц байдлаар томьёолол бичихгүй бол.

Тэгээд шууд гэдэг үг хөндөгдөөгүй учраас энэ чинь цаана нь хүн байна гэдэг юм. Одоо цэцийн тэр 12 оны дүгнэлтийг та нар үзээрэй. Түүн дотор би одоо худлаа санаагүй бол, тэр шууд гэдэг үг дээр тоглоом хийж, цэц тэрийг чинь дүгнэлт гаргаж дараа нь хүчингүй болгосон шүү дээ.

21.2 дахь хэсэг дээр байгаа. Шууд, чөлөөтэй юу юу ч гэлээ, бүх нийтээрээ, тийм нийтээрээ ч билүү. Ингээд нэг 3, 4 зарчим биччихсэн байгаа. Ийм ийм арга, зарчмаар санал хураалт явагдана гэсэн. Ийм асуулт байна.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс Раднаасэд гишүүний асуултад хариулья. Амарбаясгалан дарга 2 номер.

Д.Амарбаясгалан: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Раднаасэд гишүүний асуултад хариулья. 2012 онд Монгол Улс түүхэнд анх удаа ийм холимог системээр сонгуулийг зохион байгуулж байсан байдаг. 48, 25. Харьцааг нь ярих юм бол 65, 35 гэсэн ийм харьцаатайгаар. Тэгээд тэр сонгуулийн дараа бас зарим этгээдүүд Цэцэд хандсаны улмаас энэ шууд сонгоно гэдэгтэй холбоотойгоор тухайн үеийн Цэцийн шийдвэр, дунд суудлын шийдвэр гарсан байдаг юм байна лээ. Шууд сонгоно гэдэг нь одоо хүнийг сонгох юм гэсэн тийм өрөөсгөл ойлголтыг бас тухайн үед гаргаж байсан юм байна гэж ингэж ойлгосон.

Яагаад ингэж хэлж байгаа гэхээр 2022 оны 6 дугаар сард 22 оны 01 дүгээр дугаартай тогтоолоороо ҮХЦ их суудлын хуралдаанаараа тэр заалтыг хүчингүй болгосон юм байгаа юм. Ер нь дэлхийд сонгууль явуулдаг шалгарсан 2 систем байна л даа. Мажоритар систем, пропорциональ систем. Энэ 2 системийг

ер нь дэлхийн парламентын засаглалтай дийлэнх улс орон сонгуулийнхаа үйл ажиллагаанд шууд хэрэглэж байгаа. Энэ нь өөрөө улс төрийн намыг төлөвшүүлэх, бодлогын нам болгож хөгжүүлэх, парламент өөрөө бодлогын өрсөлдөөний талбар болох энэ хөшүүргийг хийх үүднээс энэ пропорциональ элементийг оруулж ирсэн байдаг. Улс төрийн нам бол бодлогынх байх ёстой гэдэг агуулгаар.

Нөгөө талаасаа манай Монгол Улс шиг хүн ам цөөтэй, газар нутаг томтой, газар нутгийн төлөөлөл, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилготойгоор энэ газар нутгийн төлөөлөл, хүн амын төлөөллийг төлөөлөх чадвартай энэ мажоритар системийг бас сонгож оролцуулдаг байдлаараа бол илүү явж байна.

Тэгээд сүүлийн жилүүдэд яагаад энэ өөрчлөлтийг ярих болсон юм гэхээр ер нь дэлхий нийтээрээ нэлээн даяаршил эрт явагдчихсан. Улс төрийн үзэл баримтлал бол эн тэнцүү хэмжээнд хөгжчихсөн. Аливаа төрлийн сонгууль аль ч улсад болоход ижил тэнцүү хэмжээнд одоо өрсөлдөөн бий болдог болчихсон. Үүнээсээ болоод юу болж байна вэ гэхээр одоо хамгийн сүүлд болж байгаа жишээ гэхэд БНТУ-д болж байгаа жишээгээр Ерөнхийлөгчийн сонгуульд гол 2 өрсөлдөгч нь хоорондоо 3 дөрөвхөн хувийн зөрөөтэй, 50 хүрэхгүй хувийн санал авч байгаа ийм л үзэгдэл. Үүний үр дүнгээр юу бодоод байна гэхээр нийгмийн нийт сонгогчдын 50 хувийн санал нь тэр чигтээ гээгдэж орхигдох магадлал нөхцөл үүсээд байгаа учраас энэ дээр энэ холимог системийг хэрэглэдэг болох нь зөв юм юм гээд. Тэгээд Турк ямар арга хэмжээг авсан байна гэхээр Ерөнхийлөгчийн сонгуулиа мажоритарараар явуулаад, пропорционалиар парламентын сонгуулиа явуулдаг болох нь зөв юм байна гэдэг энэ хэлбэрийг сонгож байна.

Тэгэхээр Засгийн газраас оруулж ирэхдээ энэ цэцийн гаргасан шийдвэрийг ч үндэслэсэн, дээрээс нь энэ холимог

системийг нэвтрүүлнэ. Ямар нэгэн байдлаар сонгогчийн болон сонгогдогчийн эрх зөрчигдөхгүй юм байна гэдэг үндсэн дээрээс энэ асуудлыг бол төвлөрүүлж оруулж ирсэн гэдгийг бас хэлэхийг хүсээж байна.

60, 40-тэй холбоотой асуултыг асуулаа. 60, 40 гэдэг нь үндсэндээ яах вэ, анх өргөн барьсан төслийн хувьд бол 50, 50 гээд энэ 2 систем өөрөө харилцан бие биедээ хяналт тавих чадамжтай байх нь зөв юм. Ингээж байж энэ 2 системийг хослуулан хэрэглэж байгаагийн үр дүн, ач холбогдол нь илүү гарах юм гэж үзсэн.

Ингээд яах вэ, иргэд сонгогчидтой уулзсан, Улсын Их Хурлын гишүүдээс гарч байгаа санал, улс төрийн намуудаас гарч байгаа саналуудыг үндэслээд бас одоо энэ 60, 40 гэж гэдэг яриа буюу 126 гэдэг тоо яригдаад явж байгаа юм байна гэж ингээж ойлгож байгаа юм.

Пропорциональ элементийн төрөл бол дотроо хэд хэдэн төрөл байдаг. Гэхдээ Үндсэн хуулиар бол пропорциональ гэдэг ерөнхий нэршил нь орж явна. Үүний дотоод зохицуулалт бол улс төрийн сонгуулийнхаа хуулиар зохицуулалт нь хийгдээд явна гэж ингээж харж байна. Мэдээж Засгийн газраас өргөн барихдаа 50, 50-тай буюу 76 нь мажоритараар, 76 нь пропорциональ аргаар сонгогдоно гэж ингээж зааж оруулж ирсэн. Магадгүй одоо энэ өөрчлөлттэй холбоотойгоор найруулга дээрээ аль нэг систем нь 60-аас илүүгүй хувь байна гэж томъёологдож явах болов уу гэж ингээж төсөөлж харж байна. Энэ асуудал бол ингээд ажлын хэсэг дээр яригдаад явах байх гэж бодож байна.

Пропорциональ элементийн хувьд хаалттай болон нээлттэй гэдэг ийм 2 төрлийг манай улс төрийн түвшинд нэлээн ярьдаг. Үүнийг иргэд ойлгохдоо хаалттай гэдэг нь нэрийн жагсаалт гарахгүй юм байна, нээлттэй гэдэг нь нэрийн жагсаалт гарах юм байна гэж ойлгоод байдаг. Тэгвэл энэ ойлголт бол

бас өрөөсгөл байна гэж ажлын хэсгийн зүгээс удаа дараа тайлбар хийж байгаа юм.

Хаалттай жагсаалт гэдэг маань улс төрийн намын жагсаасан жагсаалт олон түмэнд ил тод байна. Гэхдээ тэнд байгаа хүмүүс авсан саналаараа нэр дугуйлагдаж эрэмбэлэгдэхгүй ээ л гэдэг зүйлийг хаалттай гэж хэлээд байгаа юм. Тэгэхээр үүнийг цаашидаа хаалттай, нээлттэй гэж ярихаас илүүтэйгээр санал авч эрэмбэлэгдэнэ, эрэмбэлэгдэхгүй гэдгээр нь яривал илүү ач холбогдолтой. Үүний зохицуулалтыг сонгуулийн хуулиараа зохицуулаад явах юм гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн нэмж тодруулъя.

Ш.Раднаасэд: Энэ 76, 50 гэдэг хувилбар дээр нэгэнт улс төрийн намууд ч ялаад, Засгийн газар хууль санаачлагчийн хувьд энэ дээрээ санал нэг байгаа юм шиг байна гэж ойлгож байгаа юм. Өчигдөр хийсэн мэдээллийн бас. Тэгээд одоо наадхаа энэ бичих томъёоллыг энэ цэцийн гишүүдийг оруулж бичүүлье. Бид нар энд нэг юм ойлгодог. Одоо Баасандорж юу ойлгоно түүгээрээ биччих гээд байгаа байхгүй юу. Тэгсэн тэр бол Баасандоржийн л ойлголт. Наадах чинь төгс ойлголт биш байхгүй юу. Одоо Дондогмаа нэг юм ойлгоод биччихдэг, тэр нь бас Дондогмаагийн л ойлголт шүү дээ. Тэгээд энэ хуучин цэцэд байсан хүмүүсийг цэцэд ажиллаж байсан энэ Амарсанаа гуай эд нар ч гэдэг юм уу, энэ хүмүүсийг суулгаж байж энэ томъёоллыг зөв гаргахгүй бол зүгээр миний болгоомжлох үүднээс яриад байгаа юм шүү.

Шууд гэдэг чинь дахиад энэ дээр цэцэд маргаан үүсэх магадлал үүснэ. Сонгуулийн хуультай чинь нийлээд. Хаалттай системээр гэдэг юм уу, одоо нам дугуйлах хэлбэрээр тэрийг нь санал тооцогдоно гэвэл ингээд нөгөө хаалгаар гаргаад тооноор оруулаа, гаргалаа гэдэг

яриа чинь дахиж эхлээд дахиад нэг нь аваачиж цэцэд өгөх нэг юм үүсчих вий.

2 дахь юм нь, 76, 50 гээд. Ингээд хэдий нэг танхимтай ч гэсэн 2 өөр тогтолцоо ороод ирэхээр сонгууль 2 салгаж явуулж болно гэж хэн нэгэн бас мушигж тайлбарлаад, хэд хэдэн сарын зайтай ингээд хэрвээ тойргоос гарч чадахгүй бол жагсаалтаар орно, жагсаалтаар гарч чадахгүй бол тойргоор орно гээд ингээд наадах дээр чинь энэ байтугай юм бодно шүү дээ. Тийм учраас энэ томьёоллыг нэг мөр сайн бичүүлж авахгүй бол эргээд дахиад их том маргааны хаалга нээгээд хаячих вий л гэж ойлгоод байна. Энд бол бид нар ингээд ойлгоод ингэж явах юм байна, зөв байна гээд ингээд явдаг. Энэ хуулийг чинь дахиад 10, 15, 20, 30 ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Санал хэллээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар саналаа урьдчилж бичгээр ирүүлэх ёстой. Хэрэв зарчмын зөрөөтэй санал гаргах бол гэж заасан байгаа. Үүнтэй холбогдуулаад урьдчилсан байдлаар бичгээр ирүүлсэн саналын томьёолол байхгүй байна.

Ингэхээр санал хураалтыг явуулна. Гишүүд байраа эзлээрэй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулж дүнг танилцуулна.

Санал хураалт 3-ны 2-оор дэмжигдэх ёстой байгаа. Ингээд дэмжье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал дэмжигдлээ. Ингээд нийт санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжиж, 84.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж дууслаа.

Ингээд дараагийн асуудалдаа орцгооё. 2 дахь асуудал.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлбэ.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Ингээд хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, сонслоо.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. 3

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд манай Байнгын хорооноос танилцуулах шаардлагатай байгаа.

Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалалтай гишүүд Батсуурь, Пүрэвдорж, Тогтохсүрэн гэсэн гишүүд байна. Тогтохсүрэн гишүүн танилцуулна. Төрийн байгуулалтын байнгын хороонд.

Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон ажлын хэсэг болон гишүүдэд баярлалаа.

13:27

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА